



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2011 оны 12 сарын 07 өдөр

Дугаар 346

Улаанбаатар хот

Г “Албан журмын даатгагчдын холбооны дүрэм”-д 7
оруулсан нэмэлт, өөрчлөлтийг зөвшөөрөх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.1, Даатгалын тухай хуулийн 12^{1.9} дэх заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. Санхүүгийн зохицуулах хорооны 2011 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 327 дугаар тогтоолоор зөвшөөрсөн “Албан журмын даатгагчдын холбооны дүрэм”-ийн 7 дугаар зүйлийн 7.2 дахь хэсгийн “... хангана.” гэсний дараа “Холбооны гүйцэтгэх захирлыг Удирдах зөвлөлийн саналыг үндэслэн Санхүүгийн зохицуулах хороо томилж, чөлөөлнө.” гэж нэмэхийг зөвшөөрсүгэй.

2. “Албан журмын даатгагчдын холбооны дүрэм”-ийн 6 дугаар зүйлийн 6.9.3 дахь заалтыг хасахыг зөвшөөрсүгэй.

3. “Албан журмын даатгагчдын холбооны дүрэм”-д нэмэлт өөрчлөлтийг оруулж үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг Албан журмын даатгагчдын холбооны Удирдах зөвлөл/Г.Хэрлэн/-д үүрэг болгосугай.

4. Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан Санхүүгийн зохицуулах хорооны 2011 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 341 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН